



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар A/89.

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын Ойжуулалт хийх, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Эрдэнэцэцэг - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Х.Баярлах - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын хог хаягдлын менежмент, хөрс болон орчны бохирдол, инженерийн дэд бүтэц, зам тээвэр, реклам, сурталчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Бөхболд - Аймгийн Байгаль орчин, аялал

жуулчлалын газрын мэргэжилтэн

Х.Жангарзусэм - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Х.Дэмид - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо / Н.Эрдэнэцэцэг /-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Х.Дэмид /-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД



2019 тг A/89 Ch
02 00394